



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [facebook.com/Vrtcc.m0n](https://www.facebook.com/Vrtcc.m0n)
- <http://rtcc.mrtd.gov.mn>
- info@rtcc.mrtd.gov.mn
- +976 77244409


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын дугаар



Суурь бүтцийн 2020 оны 5-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан


2020 оны 5-р сард нийтдээ 101 удаагийн зурмагын тасалдал бүртгэгдсэнээс:



Зүтгүүрийн албаны 2020 оны 5-р сарын тасалдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзэхэд 85 нэгж буюу 45.69% -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалтыг өмнөх оны энэ сартай харьцуулахад энэ сард тасалдал гараагүй бөгөөд 100% -иар буурсан үзүүлэлттэй байна.



**Зорчигчийн галт тэрэгний явуулалт
5 дугаар сар**


д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелсэн	Тасалдсан
1	Сүхбаатар	63	63	0
2	Дархан	94	94	0
3	Шарын гол	62	62	0
4	Зрдэнэт	31	31	0
5	Зүүнхараа	31	31	0
6	Улаанбаатар	127	127	0
7	Айраг	10	10	0
8	Бор-Өндөр	9	9	0
9	Сайншанд	0	0	0
10	Замын-Үүд	31	31	0
Бүгд		648	648	0

Тайлан



Суурь бүтцийн 2020 оны 5-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх оны мөн энэ сартай харьцуулан үзэхэд 15 нэгж буюу **68.18%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт 4 дүгээр сар


д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелсэн	Тасалдсан
1	Сүхбаатар – Улаанбаатар	125	122	3
2	Дархан – Улаанбаатар	2	2	0
3	Дархан – Шарын гол	124	124	0
4	Дархан – Эрдэнэт	62	61	1
5	Зүүнхараа – Улаанбаатар	62	60	2
6	Айраг – Бор-Өндөр	19	19	0
7	Улаанбаатар - Сайншанд	0	0	0
8	Улаанбаатар – Замын-Үүд	62	61	1
Бүгд		456	449	7

Ачааны галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн энэ сартай харьцуулан үзэхэд энэ сард 8 нэгж буюу **22.86%** -иар буурсан үзүүлэлттэй байна.



Ачааны галт тэрэгний явуулалт 5 дүгээр сар

д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биелсэн	Тасалдсан
1	Сүхбаатар	369	369	3
2	Ерөө	126	126	0
3	Дархан-1	74	73	1
4	Дархан-2	147	145	1
5	Шарын гол	31	31	0
6	Салхит	205	201	4
7	Хөтөл	81	81	0
8	Эрдэнэт	60	60	0
9	Зүүнхараа	701	695	6
10	Толгойт	339	335	4
11	Улаанбаатар-1	64	64	0
12	Улаанбаатар-2	378	378	1
13	Амгалан	48	48	0
14	Багахангай	37	36	1
15	Маянт	19	18	0
16	Баянзүр	75	75	0
17	Чойр	695	694	1
18	Шивээ-Овоо	94	94	0
19	Олон-Овоо	75	75	0
20	Айраг	128	128	0
21	Бор-Өндөр	54	54	0
22	Өрлөн	25	25	0
23	Зүүнбаян	23	23	0
24	Улаан-Уул	4	4	0
25	Сайншанд	790	792	4
26	Замын-Үүд	787	789	1
Бүгд		5438	5409	27





Суурь бүтцийн 2020 оны 5-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх сартай харьцуулан үзэхэд тасалдлын тоо **52** нэгж буюу **43.69%** -иар буурсан үзүүлэлттэй байна.




Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлт (5 дугаар сар)

д/д	Бртвийн нэр	Галт тэрэгний тоо		
		Төлөвлөсөн	Биеэлсэн	Тасалдсан
1	Сүхбаатар – Зүүнхараа	300	307	2
2	Сүхбаатар – Дархан	52	51	1
3	Ерэн – Зүүнхараа	188	184	4
4	Дархан – Шарын гол	41	41	0
5	Дархан – Сэлэгт	97	97	0
6	Дархан – Зүүнхараа	167	167	0
7	Сэлэгт – Эрдэнэт	129	128	1
8	Зүүнхараа – Улаанбаатар	710	661	19
9	Улаанбаатар – Багануур	131	130	1
10	Улаанбаатар – Чойр	680	644	16
11	Багахангай – Чойр	22	22	0
12	Багахангай – Улаанбаатар	35	33	0
13	Багахангай – Багануур	4	4	0
14	Чойр – Сэлэнгэнд	716	706	10
15	Айраг – Бор-Өндөр	65	64	1
16	Сайншанд – Зунгийн	55	55	0
17	Сайншанд – Замын-Үүд	751	739	12
Бүгд		4160	4063	97

Нийт 101 тасалдал бүтгэгдсэний 67.33 хувь (68 тасалдал) нь зүтгүүрийн гэмтлээс үүдсэн тасалдал бүртгэгдсэн байна.

Зүтгүүртэй холбоотой 68 тасалдалын 45 (66.18 хувь) нэгжийг 2ТЭ116УМ серийн зүтгүүр, 7 (10.29 хувь) нэгжийг 2ТЭ25КМ серийн зүтгүүр, 5 (7.35 хувь) нэгжийг 2ЗАГАЛ болон 2ТЭ116УД серийн зүтгүүрүүд нь тус тус эзэлж байна.



Нийтдээ хохирлын хэмжээ 15'841'505₮ болсон байна. Үүнээс зүтгүүрийн гэмтлээс үүдэлтэй саатсан хохирлын хэмжээ 12'017'662 (75.86%) төгрөг, хоорондын замд саатсан галт тэргийг хүлээн зогсож зурмагаас гарсан тасалдлын хохирлын хэмжээ 761'640 (4.81%) төгрөг эзэлж байна.

Мөн технологийн зөрчил буюу ажилчдын буруутай үйлдлээс үүдсэн тасалдлын хохирлын хэмжээ 639'737 (4.04%) төгрөг, төмөр замын гарам, төмөр зам дээр хүн, машин, мал байсан болон дайрагдсанаас шалтгаалан гарсан тасалдлын хохирлын хэмжээ 1'076'508 (6.79%) төгрөг, бүхээгний аюулгүй байдлын систем (БАБС)-ийн доголдлоос үүссэн тасалдлын хохирлын хэмжээ 125'689 (2.04%) төгрөг, бусад шалтгаантай тасалдлын хохирлын хэмжээ 1'220'269 (7.70%) төгрөг, болж тус тус эзэлж байна.

Мэдээ, мэдээлэл



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2020 оны 05 дүгээр сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогог хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2020 оны 05 дүгээр сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.




"МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ" чиглэлээр магистрын эчнээ хөтөлбөрт хамрагдах инженерүүдийг хэлний бэлтгэлд хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.




Магистрын эчнээ сургалтад нэмэлтээр 4 хүний материалыг хүлээн авж, бүртгүүлсэн. ОХУ-ын Эрхүү хотын Зам Харилцааны Улсын Их Сургуулиас 2020.06.16-ны өдөр 01-1470-14 тоот 3 төрлийн орос хэлний бэлтгэл ангиас сонголт хийх тухай албан бичиг ирсэн. Сургалтад хамрагдах инженер нараас аль орос хэлний бэлтгэлд хамрагдах талаар лавлан санал авч нэгтгэсэн. 2020.07.20-08.10 хооронд Эрхүү хотын Зам Харилцааны Улсын Их Сургуулийн орос хэлний бэлтгэлийн 30 цагийн алсын зайн сургалтад хамрагдах тухай 153 тоот албан бичгийг 2020.06.23 өдөр нэмж бүртгүүлсэн хүмүүсийн материалуудын хамт цахим хаягаар хүргүүлсэн.

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2020 оны тавдугаар сард 152.7 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2530.3 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр /2020 оны 5 дугаар сард/



Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2020 оны тавдугаар сард 384.3 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилтаар 2020 оны тавдугаар сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1902.2 мян.тн ачсан байна.

Нүүрс	35%
Төмрийн хүдэр	37%
Бусад ачаа	10%
Барилгын материал	9%
Жонш	4%
Зэс, молибдений баяжмал	3%
Нефтийн бүтээгдэхүүн	2%



2020 оны 5 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 705 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -27.8%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 12016.4 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.

ИНФОГРАФИК





Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил" болгон зарлах тухай А/01 дүгээр тушаалыг "ГТХЗНТ" УТҮГ-т хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2020.06.09-ний 134 тоот албан бичгээр тайлагнав.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргэж тайлагнав.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайлан хамгаалалтын үед гарсан саналыг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2020.06.10-ны 138 тоот албан бичгээр хүргүүллээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2018 оны XXII, 2019 оны XXV, XXXI хуралдааны шийдвэрийн биелэлтийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэв.

"ГТХЗНТ" УТҮГ-ын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө /гүйцэтгэлийн тайлан/-ний биелэлтийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2020.06.19-ний 150 тоот албан бичгээр хүргэж тайлагнав.

"ГТХЗНТ" УТҮГ-ын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2020.06.19-ний өдөр хүргэж танилцуулсан.



Төмөр замын мэргэжлийн тайлбар толь бичиг боловсруулах ажлын хүрээнд Зам замын аж ахуйн тайлбар толь 160 хуудас, мэдээллийн технологийн тайлбар толь 10 хуудас, дохиолол холбооны тайлбар толь 35 хуудас, хөдлөх бүрэлдэхүүний тайлбар толь 68 хуудас, тээврийн удирдлагын нэр томъёоны тайлбар толь 100 хуудас нийт 350 хуудас эх загвар гаргаж, нэр томъёоны стандарт боловсруулсан байгууллага, мэргэжилтнүүдээс санал, зөвшөөрөл авч ажиллаж байна.



Мэдээ, мэдээлэл

“ГТХЗНТ” УТУГ нь Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох ажлыг хариуцан ажиллаж байна.

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох, санал дүгнэлт гаргах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлын хүрээнд: “ГТХЗНТ” УТУГ-ын захирлын 2020.05.28-ны өдрийн А/30 дугаар тушаалаар гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн ажиллах заавар, бүрэлдэхүүнийг батлуулсан. 2020.06.26-ны өдрийн байдлаар төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлт гаргасан 17 аж ахуйн нэгж, байгууллага хүсэлт ирүүлээд байна. Гэрчилгээ хүссэн 17 хуулийн этгээдийн 1546 хуудас баримт бичгийн бүрдэлийг цахим хэлбэрт оруулан, нягтлан шалгасан. Гэрчилгээжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлын хэсгийн 2020.06.08,12-ны өдрүүдийн хурлаар 8 хуулийн этгээдийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, дүгнэлтийг ЗТХЯ-нд уламжилж, шаардлага хангаагүй баримтыг хуулийн этгээдэд буцаан хүргүүлсэн.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЧИЛГЭЭ



Гэрчилгээ олгох журмын зорилго

-  Сайрмал төрөлгүй, найдвартай, хуртамтай үйлчилгээг үзүүлэх мэдэлгөний аюулгүй байдал болон үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх
-  Тээх, нөөтрүүлэх чадвар болон өвөрмөцний нөхцөл байдлыг тодорхойлох
-  Сайбэрт дэвшилтэд техник, технологи нөөтрүүлэх

Гэрчилгээжүүлэх байгууллагын үйл ажиллагаа

- ✓ Гэрчилгээ бүхий объект, үйл ажиллагаа нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл шаардлагаг хангаж байгаа эсэхийг хянан шалгах, гэрчилгээ олгох, нутагцаг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, нөхөн олгох, буцаан олгох
- ✓ Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх

Баримтлах зарчим

-  Хууль тогтоомж
-  Дотоо мөрдөн
-  Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа

MNS 5523-2013

Гэрчилгээжүүлэлтийн төрөл:

Дараах үйл ажиллагааг гэрчилгээжүүлнэ:

- Дагнасан хэрэглээний замын дэвд, доод бүтцийн засвар, арчлалт гүйцэтгэх;
- Төмөр замын зураг төсөл боловсруулах;
- Дагнасан хэрэглээний зам, талбай барих;
- Дагнасан хэрэглээний замд салхээний ажил гүйцэтгэх;
- Төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн техникийн үйлэг, үйлчилгээ гүйцэтгэх;
- Зүүтгүйний техникийн үйлэг, үйлчилгээ гүйцэтгэх;
- Валсоны техникийн үйлэг, үйлчилгээ гүйцэтгэх;
- Төмөр замын тээвэр зурчлалын үйл ажиллагаа эрхлэх;
- Хатуу тоосгоор багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх;

Дараах объект/уудыг гэрчилгээжүүлнэ:

- Суурь бүтэц/анхлаг чиглэлээр;
- Нийтийн хэрэглээний зам, талбай;
- Дагнасан хэрэглээний зам, талбай;
- Өртөг, зорил /төмөр замын дохиолол, холбооны байгууламж/

Хөдөлж бүрэлдэхүүний чиглэлээр:

- Бүх төрлийн нутгуур;
- Бүх төрлийн агаарын вагон;
- Бүх төрлийн зорчигчийн вагон;
- Сэргэн богино, ган унтраах галт тэрэг;
- Зам засвар, арчлалт, өрөөлсөөр, хэмжээт хийх бүх төрлийн машин механизм;

Гэрчилгээний загвар




Объект, үйл ажиллагааны гэрчилгээ хүсэгчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх дараалал





Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээ олгох ажлын журмын мэдээлэл









Тохирлын үнэлгээ, үл эвдэх сорилын лаборатори байгуулах ажлын судалгаа хийх ажлын хүрээнд төмөр замын салбарын тохирлын үнэлгээ, үл эвдэх сорилын лабораторийн өнөөгийн байдлын тухай танилцуулга бэлтгэж төвийн удирдлагад танилцуулсан.

Үүнд: тохирлын үнэлгээний эрхзүйн орчин, холбогдох стандартууд, ОХУ-ын гэрчилгээжүүлэлт, лицензийн тухай, “УБТЗ” ХНН-ийн тохирлын үнэлгээний нөхцөл байдал, барилгын төмөр бетон бүтээц болон хиймэл төхөөрөмжийн тохирлын үнэлгээний орчин, хэмжилт туршилтын лабораториуд, цаашид төвийн зүгээс тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болох төлөвлөгөө зэргийг танилцуулсан.

Үл эвдэх сорилын лаборатори манай улсын хэмжээнд МИАТ компани, Оюу толгой компаниудад иж бүрнээр ажил үүрэг гүйцэтгэж, сорилт туршилт хийж байна. Төмөр замын салбарын үл эвдэх сорилын лабораторийг төвийн барилга баригдсаны дараа түүний суурийн давхарт байгуулах боломжтой талаар судалж Япон улсын “Жайка” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад танилцуулсан. Бид төмөр замын салбарын зам төмөр, төмөр бетон дэр, гүүр хоолойн төмөр бетон бүтээц, хөдлөх бүрэлдэхүүн, хөлдөх бүрэлдэхүүний хариуцлагатай эд ангид тохирлын үнэлгээ хийж тохирлын баталгааны гэрчилгээ өгөх шаардлагатай байна.

Зам тээврийн, хөгжлийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 161 дугаар тушаалын дагуу ГТХЗНТөв нь ЗТХЯ-тай хамтран төмөр замын салбарт тохирлын үнэлгээний талаар гаргасан бичиг баримтуудыг сайжруулан, олон улсын жишигт хүргэж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Төмөр замын шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлт өөрчлөлтийг тусгасан. Уг өөрчлөлтийн гол нь ГТХЗНТөвийг салбарын итгэмжлэгдсэн лабораториудын ажиллагаанд тулгуурлан тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болгохоор хуульчлах зорилт тавин ажиллаж Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх хүлээлцэх журамд түрээсийн хөдлөх бүрэлдэхүүний талаар заалт оруулсан.

Одоогийн байдлаар тохирлын үнэлгээний талаар хийгдэж буй ажлуудаас дурдвал ЗТХЯ-наас хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын гэрчилгээ олгох, бүтээгдэхүүний хувьд төмөр бетон дэр, гүүрийн дам нуруу, барилгын бетон хийцийн тохирлын үнэлгээний гэрчилгээг БАК (барилга архитектур корпорац) ISO/IEC17065, ISO/IEC17067 стандартаар олгож байна.





ИВУ: Испани улсын үндэсний төмөр замын оператор “RENFE” ойрын жилүүдэд зорчигч тээврийн хөдөлгөөнийг сайжруулахаар төлөвлөж байна.



Зорчигч тээврийн галт тэрэгний паркуудыг шинэчлэхийн тулд хотын захын болон бүс нутгийн харилцаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн эхний захиалга нь Мурсия, Кантабрия зэрэг мужуудад ашиглалтад оруулах зорилгоор 1000 мм-ийн цариг дээр аялах 31 цахилгаан галт тэрэг захиалахаар гэрээнд заасан байна.

Мөн Мадрид хотын төмөр замын сүлжээнд багтаамж сайтай хотын захын шугамд аялах галт тэрэг, Экстремадура болон Арагон мужуудын захын шугамд зориулсан хосолсон галт тэрэг худалдаж авахаар төлөвлөсөн.



БНФУ: Финланд улсын өмнөд хэсэгт дэд бүтцийн хэд хэдэн төсөл хэрэгжиж байна.

Нэн ялангуяа Хельсинкийн вокзалын хойд хэсэгт байрлах Пасила өртөөг сэргээн босгох ажилд их хэмжээний хөрөнгө зарцуулсан. Энэ өртөөгөөр хэд хэдэн шугам дамждаг бөгөөд галт тэрэгнүүд энэ өртөөгөөр дамжин нийслэлийн гол депо хүрдэг. Дамжин өнгөрөх Европын TEN-T сүлжээ ба Connecting Europe Facility хөтөлбөрийн хүрээнд Европын холбооны сангаас санхүүжүүлдэг. Өртөөний хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд 1500 м урт нэмэлт зам тавих, зорчигчдын шинэ тавцан барихаар төлөвлөжээ. Энэ ажлыг 2020 оны эцэс гэхэд дуусгахаар төлөвлөж байгаа бөгөөд нийслэлийн төмөр замын уулзварын хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын ажлыг сайжруулах зорилгоор хөрш зэргэлдээ ялгах өртөөг сэргээн засварлахаар төлөвлөж байна.



2023 он гэхэд 60 км орчим урттай Лумумаки-Иматра шугам дээр 2018 онд эхлүүлсэн хоёр дахь замыг тавих ажлыг дуусгахаар төлөвлөж байна. Үүний үр дүнд их хэмжээний ачааг тээвэрлэдэг хамгийн ачаалалтай нэг чиглэлийн үйл ажиллагааны орчин сайжирч түүнчлэн Хельсинки-Иоенку чиглэл ба, Хельсинки-Санкт-Петербург хэсгийн зорчигчдыг нэвтэрүүлдэх боломжтой болох юм.



Өндөр хурдны төмөр замын ачаар Итали, Францын хооронд хил дамнансан тээвэрлэлт өргөжих төлөвлөгөөтэй байна.

Одоогийн байдлаар Итали улсын зорчигч тээврийн төмөр замын операторын охин компани болох “Тэлло” нь Итали болон Франц улсын хооронд Милан-Турин-Парис чиглэлд шөнийн галт тэргээр төмөр замын зорчигч тээврийг гүйцэтгэдэг. Өдрийн цагаар галт тэрэг Милан, Генуя, Ниццагийн хооронд аялдаг.



Түүнээс гадна “Тэлло” компани нь Милан, Парисын хооронд өндөр хурдны төмөр замаар олон улсын тээврийг зохион байгуулахаар төлөвлөн, зөвшөөрөл авахаар Францын „Арафер Төмөр замын газар“-тай холбоо тогтоон ажиллаж байна. “Телло” компани нь “Frecciarossa 1000” галт тэрэгний чиглэлийн дагуу ердийн болон өндөр хурдны төмөр замын шугамд ашиглах боломжтой дохиоллын системээр тоногдсон.





ИБУИНВУ: 2019 онд Их Британи улс “Азума” галт тэрэгний арилжааны ажиллагаагаа эхэлсэн.



Шинэ хөдлөх бүрэлдэхүүнийг Их Британийн Тээврийн яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр Intercity Express хөтөлбөрийн хүрээнд бүтээсэн. Шинэ хөдлөх бүрэлдэхүүнийг Английн холын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг “LNER” компанийн захиалгаар “Hitachi Rail Europe” ба Жон Лаинг компанийн Agility Trains консорциум үйлдвэрлэсэн.



225 км/цаг хурдлах зориулалттай галт тэргийг Японы технологийг ашиглан Их Британи улсын “Ньютон Айклифф” үйлдвэрт үйлдвэрлэсэн. “Азума” галт тэрэгний вагонуудын тохилог байдлыг сайжруулсан. Вагон нь нэгдүгээр зэрэглэлийн вагонд байдаг түшлэгтэй өргөн суудалтай, зөөврийн компьютертой ажиллах өргөн ширээ, USB порт, цахилгаан залгуураар тоноглогдсон. “LNER” операторын “Азума” галт тэрэгний парк нь таван ба есөн вагонтой хосолсон зүтгүүр бүхий 800 ба 801 цуврал экспресс галт тэрэгнээс бүрдэнэ. Эхний галт тэрэг Лондонгийн Кингс-Кросс ба Лидсийн хоорондох зам дээр аялж эхэлсэн.



Венец дахь Италийн далайн боомт ба Германы Дуйсбург дахь терминалын хооронд тогтмол ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулдаг.

Венецээс Дуйсбург руу долоо хоногт 3 удаа ачаа тээвэрлэдэг ачааны галт тэрэгний оператор нь Австрийн Холбооны төмөр замын охин компани болох Rail Cardo групп юм. Скало Маргера боомтын төмөр замын өртөө нь жилд 700 орчим мянган TEU контейнер дамжуулдаг. RCG нь Дуйсбург хотоор дамжин өнгөрөх замыг Адриатик ба Скандинавын орнуудын боомтуудын хоорондох ачааны урсгалын өсөлтийг нэмэгдүүлэх ирээдүйтэй гэж үздэг. Триест, Копер, Рижка боомтуудаар Европ руу дамжин өнгөрөх ачаа татахаар төлөвлөж байна.

